



Оксфордын  
уншлагын  
мод

# БАГШИЙН НОМ

Шатлал 6  
Үлгэрүүд



Родерик Хант  
Алекс Бричта



## Багшийн ном



### Цэцэрлэгт хүрээлэнд

Унших үйл ажиллагаа	5
Ярих, сонсох үйл ажиллагаа	7
Бичих үйл ажиллагаа	7



### Киппер ба аварга биетэн

Унших үйл ажиллагаа	8
Ярих, сонсох үйл ажиллагаа	10
Бичих үйл ажиллагаа	10



### Зугаалга

Унших үйл ажиллагаа	11
Ярих, сонсох үйл ажиллагаа	13
Бичих үйл ажиллагаа	13



### Динозавруудын өлгий

Унших үйл ажиллагаа	14
Ярих, сонсох үйл ажиллагаа	16
Бичих үйл ажиллагаа	16



### Эрдэнэсийн авдар

Унших үйл ажиллагаа	17
Ярих, сонсох үйл ажиллагаа	19
Бичих үйл ажиллагаа	19

## Өмнөх үг

Шатлал 6 дахь 5-н цуврал үлгэр нь Биф, Чип, Киппер болон түүний найзүүдүн адал явдлыг үргэлжлүүлэн өгүүлдэг юм. «Шидэт түлхүүр» нь тайван орчинд уран зөгнөл, адал явдал өрнөх боломжийг олгодог. Шинэ үг болон өгүүлбэрийн бутцийг хянах, үлгэрийн өмнөх шатлалын түлхүүр үгс нь давтагдаг юм. Энэ төвшинд хүүхдүүдээр үлгэрийг ярилцуулж бие даан өөртөө итгэлтэй уншуулах нь чухал юм. Өмнөх шатлалуудад үгсийн сангийн мэдлэгээ өргөжүүлснээр шинэ үгийн утга болон авиа зүйн мэдлэгээ нэгтгэх суурийг тавьж өгч байна. Олон давтагдах үгсийн хүснэгтийг ашиглаж хүүхдүүд гол хэрэгцээтэй үгнүүдээз цээжилж болно.

## Номыг хэрхэн танилцуулах вэ?

Шатлал 6 дахь үлгэрүүдийг бие даан уншихаас өмнө танилцуулах нь чухал юм. Энэ нь хүүхдүүдэд өөртөө итгэлтэй бие даан унших боломж олгож, зохиолын талаар хангалттай мэдээлэл өгөх болно. Үлгэрийг уншихын өмнө хавтсан дээрх зургийн талаар ярилц. Арын хавтсан дээрх тодорхойлолтыг уншиж, үлгэр юуны талаар өгүүлж байгаа тухай таамаглуул. Номоор хамтдаа аялж, зургийг үзэж ярилц. Ойлгоход бэрхшээлтэй шинэ үгнүүдийг уншиж нүдэл. Энэхүү товхимол нь бүлгээр болон бие дааж номыг унших үйл ажиллагаанд зөвлөгөө өгдөг. Номын санамж, санаанууд нь бүлгээр болон ганцаарчлан уншихад зориулсан байдаг. Бичих, ярих, сонсох үйл ажиллагаа болон амьдрал хичээлийн уялдаанд зөвлөгөө өгдөг. Унших явцад өгч байдаг эдгээр зөвлөгөөнүүдийг цаг ямагт хэрэглэж болно.

## *Гэрийн карт*

Ном бүхэнд гэртээ уншихад зориулагдсан бэлэн карт бий. Эдгээр нь эцэг эхчүүдийг хүүхдүүдтэйгээ ажиллахыг нехерсгээр сануулсан санамж болж өгдөг юм. Номын гарчиг бүхэнд хамарагдах картыг та гэртээ үлдээж болно.

## **Унших чадвар**

Шатлал 6-г уншсанаар:

- Дүрүүдийн сонирхол сэтгэгдлийг тодорхойлох
- Өргөн хүрээний үгсийн сантай болох
- Зохиолын янз бүрийн утга санааг ойлгох
- Зохиолын дүрүүд болон үйл явдлыг зөв танилцуулах
- Бие даан бичих үйл ажиллагааг дэмжих зэрэг чадваруудыг хөгжүүлнэ.

## Үгсийн сангийн хүснэгт

Цэцэрлэгт	Олон давтагдах үгс	орох, ажиллах, дотогшоо, туслах, байшин, гүйсэн, дургүй, түлхэв, маш, хүсэх, ёстой, хэлэв
	Эхэд хамаатай үгс	лонх, зөгий, авиаах, элсэн цөл, цэцгийн ой, жижгэрэх, дотор, ширэнгэ, уул, гадаа, бороо, гүзэлзэн
Киппер, Үлэмж биетэн хоёр	Олон давтагдах үгс	ирсэн, туслах, байшин, амьдардаг, одоо, хуучин, хүмүүс, харав, тэдний, бид
	Эхэд хамаатай үгс	адал явдал, ууртай, шилтгээн, аварга хүн, хөтөлбөр, дээвэр, замын тэмдэг, чулуу, тосгон, шидсэн
Зугаалга	Олон давтагдах үгс	туслах, энд, хүсэх, гэр, сууцгаах, сургууль, хэлэв, тухай
	Эхэд хамаатай үгс	зургийн аппарат, матчууд, үлэг гүрвэлүүд, заан, итгэх, хадгатай, арслангүүд, музей, дэргэд, фото зураг, бороо, өрөө, гутал, тасалбар, жорлон, хэлсэн, ус, амьтны хүрээлэн
Үлэг гүрвэлийн орон	Олон давтагдах үгс	өөр, туслах, байшин, агдаг, ус, хэлэх
	Эхэд хамаатай үгс	зургийн аппарат, авирсан, үлэг гүрвэлүүд, аварга, ниссэн, мөр, олсон, хаалга, уул, фото зураг, нисдэг гүрвэл
Эрдэнэсийн авдар	Олон давтагдах үгс	хэлэх, эхлах, сэлэлт, асуух, сэлэх
	Эхэд хамаатай үгс	далайн хясаа, зүүлт, наймаалж, гайхах, сэлсэн, эрдэнэ, усан доор, цөм, аварга загас



## Цэцэрлэгт хүрээлэнд

### Уншихын өмнө

- Хүүхдүүдээр гарчгийг уншуулж, хавтасны зургийг үзүүлээд тэднээс, Цэцэг ургамлууд том уу, эсвэл хүүхдүүд том уу? Та нар юу гэж бодож байна вэ? гэж асуу.
- Гарчгийг хамтдаа унш.
- Үлгэрийн тайлбар zuрагнуудыг хараад юу болж байгаа тухай ярилц.

### Унших үед

- Хүүхдүүдээр үлгэрийг уншуул. Уншиж байхад нь магтаж урамшуулж, шаардлагатай бол сануулан хэлж өг.
- Болж байгаа үйл явдлыг ойлгосныг нь шалган асууж, хүүхэд нэг бүрээс хариултыг нь сонс.  
Жишээ нь: 11-р хуудсан дахь Бифийн ятгалгаар тэднийг цэл үрүү бууж ирэхэд, Киппер яагаад «үгүй» гэж хэлсэн бэ? гэж асуу.
- Цэцгийн ваар, элсэн цооног гэх мэтийн нийлмэл үгийг уншихад бэрхшээлтэй байгаа бол түүний нийлсэн угнуудийг нь салгаж олуул.

#### Ажиглалт

Олон давтагдах үгсийг өөртөө итгэлтэйгээр унших.

Шинэ үгийг нүдлэхдээ өргөн хүрээний арга хэрэглэх.

## Бүлгээр болон бие даан унших үйл ажиллагаа.

### Эхийн төвшинд ажиллах

**Зорилт** Үлгэрийн цаг үе болон дарааллын холбоог ойлгох.  
Самбар дээр эдгээр гурван өгүүлбэрийг бичих хэрэгтэй.

Тэд уул уруу явсан.  
Флоппи муур элдэж хөөсөн.  
Хүүхдүүд өвсөн дунд байв.

- «эхлээд», «дараа нь», «сүүлд нь» гэсэн үгнүүдийг ашиглаж, үлгэрт болж байгаа дээрх үйл явдлыг дараалуулан яриул.
- Хүүхдүүдээр үлгэрээс тохиолдсон үйл явдлыг ярих гурван өгүүлбэрийг сонгуулаад «эхлээд», «дараа нь», «сүүлд нь» гэсэн гурван үгнүүдээ ашиглан бичүүл.

**Ажиглалт**

Хүүхдүүд үйл явдлыг дараалан харуулсан өгүүлбэр сонгож байна уу?  
Хүүхдүүд цэг тэмдэг болон том үсэг хэрэглэхээ санаж байна уу?

**Өгүүлбэрийн төвшинд ажиллах**

**Зорилт** Хүүхдүүд чанга үншиж байхдаа хэллэгтээ тохируулан цэг, тэмдгийн зөв хэрэглээг мэдэж авах.

- Хүүхдүүдтэйгээ хамт 8 дугаар хуудсыг хар. Эхэд байгаа Асуултын тэмдгийг олуулаад, өгүүлбэрийг хэрхэн үнших талаар зөвлөгөөг ег.
- Хүүхдүүдээр 8-17-р хуудсыг хамтад нь уншуулаад, хүүхэд бүрээр хуудсыг солилцуул. Зохиолын баатруудын хэлж байгаа аргаар үгнүүдийг уншуулаад, өөрсдийнх нь харж байгаа цэг тэмдгийг зөв хэрэглүүл.

**Ажиглалт**

Асуултын тэмдэгтэй өгүүлбэрийн өрнөлтийг зөв хэрэглэж байна уу?  
Ярианы хэлбэрийг оруулсан үлгэрийн бусад бүлгүүдээс илүү яруу уншигдаж байна гэдгийг хүүхдүүд ойлгож байна уу?

**Үгийн төвшинд ажиллах**

**Зорилт** Урт эгшээс бүтсэн үгнүүдийг үншиж үсэглэх аргыг өргөжүүлж давтуулах.

- Эдгэр үгнүүдийг самбар дээр бичээд хэрхэн үсэглэж, ямар авиа гаргаж байгаа тухай ярилц. Нэр, тоглоом, галт тэрэг, зэгий, суудал, хөл гэх мэт.
- Хүүхдүүдэд номыг үзүүлж, ижил авиа үсэг орсон өөр б-н үгийг олуул.

**Ажиглалт**

Ижил авиа гаргадаг мөртлөө өөр үсэглэлтэй үгнүүдийг тогтоож байна уу?

**Ярих, сонсох үйл ажиллагаа**

**Зорилт** Ээлжээр яриулах үзэл бодол болон үйл ажиллагаагаа илэрхийлэх.

- Хүүхдүүдийг үлгэрийн баатрууд шиг өөрсдийг нь жижигхэн гэж төсөөлүүл.
- Шавжнуудыг харж, элсэн цооногт ирж өвсөн дунд замаа олох гэх оролдож байхдаа зохиолын баатрууд юу мэдэрсэн талаар ярилц.
- Өөрийн цэцэрлэг болон цэцэрлэгт хүрээлэнд нэг удаа өчүүхэн болчих юм бол ямар байх талаар тодорхойлуул. «Хөгжилтэй байх болно», «Аймар аюултай байх болно» гэсэн хариултуудыг хүүхэд нэг бүрчлэн хэлүүл.

**Бичих үйл ажиллагаа**

**Зорилт** Үйл явдлын дараалал, бүтцэд хэлний цагийг хэрэглэх.

- Тохиолдсон үйл явдлыг бодуулж, хүүхдүүдээр үлгэрийг яриул.
- Самбар дээр цаг хугацааг илэрхийлсэн үгнүүдийг бич. Жишээ нь: энэ хооронд, дараа нь, гэнэт, сүүлд нь гэх мэт.
- Хүүхдүүдээр цэцэрлэг болон цэцэрлэгт хүрээлэнд жижигхэн болчихвол ямар байх талаар үйл явдлын дарааллыг үзүүлсэн дээрх үгнүүдийг хэрэглэж бичүүл.

**Амьдрал, хичээлийн уялдаа.**

◀▶ Математик: хэмжээ, дурс, орон зай



## Киппер ба аварга биетэн

### Уншихын өмнө

- Хавтсан дээрх зургийг харуулж гарчгийг болон арын хавтсан дээрх үргүүдийг уншуулаад энэ үлгэрт хэнийг аварга биетэн болно гэж бодож байна вэ? гэж асуу.
- Хүүхдүүдийн санааг батлах зорилгоор номыг 9-р хуудас хүртэл товчхон гүйлгэн харуул.

### Унших үед

- Хүүхдүүдээр үлгэрийг уншуул. Уншиж байхад нь магтан урамшуулж, шаардлагатай бол сануулан хэлж ег.
- Үлгэрийн талаар хүхэд нэг бурчлэн асууж, хариултыг сонс. Жишээ нь: Кипперийг яагаад айсан гэж чи бодож байна вэ? Хүмүүс яагаад Кипперт дургүй байна вэ? Тэр ямар нэгэн алдаатай зүйл хийсэн үү?

#### Ажиглалт

- Олон давтагдаж байгаа үгийг нүдэлж унших.
- Хэлээд болон цэг тэмдгийг тохиромжтой илэрхийлж унших.
- Эхлээд Киппер яагаад тосгоны хүмүүсийн дургүйг хүргэсэн шалтгааныг ойлгох.

## Бүлгээр болон бие даан унших үйл ажиллагаа

### Эхийн төвшинд ажиллах

**Зорилт** Үлгэрийн өрнөлтэй холбоотой үйл явдлыг мэдэж ярилцах.

Самбар дээр үлгэрийн талаарх дараах асуултуудыг бичих хэрэгтэй:

Киппер Бифийг авахаар яагаад гүйсэн бэ?

Киппер яагаад тосгон уруу явсан бэ?

Киппер яагаад уйлсан бэ?

Тосгоны хүмүүс яагаад «Сайн, том Киппер» гэж хэлсэн бэ?

Аварга биетэн яагаад маш их уурласан бэ?

- Хүүхдүүдийг хос хосоор нь номыг гүйлгэн харуулж, эдгээр асуултын хариултыг олуулж, хооронд нь ярилцуул.
- Хүүхэд нэг бүрчлэн шинэ асуулт бичүүлж, түүнийг нь хооронд нь солилцуулж, хариулж бичүүлж, шаардлагатай бол номноосоо тусламж авч болно.

**Ажиглалт**

Хүүхдүүд үлгэрт Кипперийн хийж байгаа зүйлийн шалтгааныг ойлгож байна уу?

**Өгүүлбэрийн төвшинд ажиллах**

**Зорилт** Өгүүлбэрийг холбодог үг хэллэгийн жишээнүүд олох.

- Үйл явдлын дарааллыг харуулсан өгүүлбэрийг холбоход хэрэглэдэг үгнүүдийг хүүхдүүдтэйгээ ярилц. Жишээ нь: «өмнө нь», «дараа нь», «тэгээд», «сүүлд нь» гэх мэт бичихдээ хэрэглэж болох үгийн жагсаалтыг хүүхдүүдтэйгээ хамт бэлд.
- Самбар дээр «Киппер тосгон уруу явав» гэж бич.
- Хэрэглэх үгнүүдээс жагсаалтаасаа авч, дараа нь юу тохиолдож байгааг бичүүл.

**Ажиглалт**

Хүүхдүүд өгүүлбэрийг том үсгээр эхэлж бичнэ гэдгийг санаж байна уу?

**Үгийн төвшинд ажиллах**

**Зорилт** Урт эгшгээс бүтсэн үгнүүдийг уншиж, үсэглэх аргыг өргөжүүлж, давтуулах.  
Танд зарлалын цаас хэрэг болно.

- Самбар дээр «Аварга биетэн» гэж бичээд А авианы тухай ярилц. Энэхүү авиа орсон өөр үгнүүдийг үлгэрээс олуул.
- Эдээр үгнүүдээ зарлалын цаасан дээр бич.

- Өөрсдөд нь тохиолдсон явдлаас нь ургуулж, энэ авиа орсон бусад үгнүүдийг хүүхдүүдээр бодож олуулаад мөн цаасан дээрээ жагсаан бич.
- Ангид цаасыг дэлгэн харуулаад шинэ үгнүүдийг хүүхдүүдээр нэмж хэлүүл.

**Ажиглалт** Хүүхдүүд урт богино эгшгийг ялгаж чадаж байна уу?

### Ярих, сонсох үйл ажиллагаа

**Зорилт** Хэлсэн үгийг эмхтгэх, холбогдох тодорхойлолт хийх.  
Бусадтай ажиллаж байхдаа өөрийн үүргээ ухаарч, бүтээлч байх.

- Кипперийн дурд тоглох хүүхдийг эзлжээр сонгож, дурд тоглуул.
- Кипперийг бусад хүүхдүүдээр аварга биетэн байх ямар вэ? Үлгэрт тэр яагаад эдгээр зүйлүүдийг хийж байна вэ?  
гэсэн Кипперийг тодорхойлох асуултуудыг асуулга.

### Бичих үйл ажиллагаа

**Зорилт** Цаг хугацааг илэрхийлж байгаа үгийг үйл явдлын бүтэц дараалалд хэрэглэх.

- Хүүхдүүдийг аварга биетэн болоод сургууль дээрээ очиж байна гэж төсөөлүүл.
- Тэднийг жирийн хүн байхаас ямар ялгаатай, ямар бэрхшээлүүд тохиолдож байна гэдгийг тодорхойлуул.  
Жишээ нь: намхан хаалга, очуухэн сандлууд гэх мэт. Үйл явдлыг тодорхойлоход туслах хэрэгтэй бол хүүхдүүдийг аварга биетийн дурд тоглохыг нь зөвшөөр.
- Аварга биетэн болоод сургууль дээрээ очсон сэтгэгдлийг нь тодорхойлон бичүүл.

### Амьдрал, хичээлийн уялдаа

◀ ▶ Дадал итгэлээ хөгжүүлэх: Давид Голиат хоёрын үлгэр.



## Зугаалга

### Уншихын өмнө

- Хавтсан дээрх зургийг хараад юу болж байгааг ярилц. Арын хавтсан дээрх үгийг уншуулаад үлгэрт юу тохиолдоно гэж бодож байгаа талаар яриул.
- Дүрүүд нь хаашаа явж байгааг мэдэхийн тулд номыг товчхон гүйлгэн харуул.

### Унших үед

- Хүүхдүүдээр үлгэрийг уншуулж, уншиж байхад нь магтаж урамшуулж, шаардлагатай бол сануулан хэлж өг.
- Шинэ үзээ нүдлэхдээ зургийн дарааллыг хэрэглэхэд нь урамшуул.
- Хэрэв хүүхдүүд 15-р хуудсан дах Алатозавр гэдэг үгийг хэлэхэд бэрхшээлтэй байгаа бол түүнийг үеэр таслан уншуул.

#### Ажиглалт

- Хэлзүйн болон цэг тэмдгийн тохиромжтой хэлбэрээр үг хэллэгийг унших.
- Шинэ үгийг нүдлэхдээ өргөн хүрээний арга хэрглэх.
- Зохиолын баатрууд яагаад музей үрүү явсныг ойлгох.

## Бүлгээр болон бие дааж унших үйл ажиллагаа

### Эхийн төвшинд ажиллах

**Зорилт** Эхийн аман уншлагыг нь харьцуулж, ярианы болон бичгийн хэлний хоорондын ялгааг ухаарах.

- Хүүхдүүдийг хамтад нь ажиллуулж, үлгэрийг бие биедээ зэлжээр ярьж өгөх, тэгээд хүүхдүүд эхийг гүйлгэн харж, вөрсдийн хувилбартайгаа харьцуулна.

- Хүүхдүүдээр өөрсдийнх нь хувилбарыг яриулж, ярианы хоорондох ялгааг нь ярилц. Бусад хүүхдүүд нь ярианаас номон дахь хувилбарын үгийг бүтэн хэрэглэж байна уу, хагас хэрэглэж байна уу гэдгийг олно.

**Ажиглалт**

Хүүхдүүд номын өгүүлбэр хэрэглэхгүйгээр үлгэрийг ярж чадаж байна уу?  
Хүүхдүүд үлгэрийг өөрийн үгээр ярж байна уу?

### Өгүүлбэрийн төвшинд ажиллах

**Зорилт** Тохиромжтой илэрхийллийг зөв гаргахын тулд чангаар уншихдаа цэг, тэмдэг, таслалыг тооцоолж таних.

- Хүүхдүүдийг хоёр хоёроор нь ажиллуулж, хэлсэн үгнүүдийг зэлжээр уншуул. Эхэд гарч буй тохиромжтой илэрхийлүүдийг хэрэглэхэд нь урамшуул.
- Сэтгэлийн хөдлөлөө илэрхийлж уншихад хүүхдүүдэд юу их тус болж байгааг бүлгээрээ ярилц. Жишээ нь: цэг тэмдэг, таслал.

**Ажиглалт**

Хүүхдүүд таслалыг уншихдаа зогсолт хийж байна уу?  
Анхаарлын болон асуултын тэмдгийг уншихад өгүүлбэрийн хэмнэл өөрчлөгдж байна уу?

### Үгийн төвшинд ажиллах

**Зорилт** Өөр үсэглэлтэй, янз бүрийн дуудлагатай үгнүүдийг анилж, ялгах.

Дутуу үтэй эдгээр өгүүлбэрүүдийг самбар дээр бичих хэрэгтэй.

Бид амьтны хүрээлэн ... явж байна  
Ус уруу ... бүү ойрт.  
Бид бүгд ... гутал өмсдөг.

- «үрүү», «хэт», «хоёр» зэрэг үгнүүдийн үүргийг хүүхдүүдтэйгээ ярилц.

- Хүүхдүүдээр самбар дээрх өгүүлбэрийг уншуулж, дутуу үгнүүдийг зөв нөхүүлэн бичүүл.
- Хүүхдүүдээр үлгэрийг нийтэд нь үелэн уншуул.
- Хүүхдүүд гурван шинэ өгүүлбэрийг зөв зохион бичиж чадаж байна уу?

*Ажиглалт*

Хүүхдүүд өөр өөр үелэн уншигддаг үгнүүдийг ойлгож байна уу?

### Ярих, сонсох үйл ажиллагаа

**Зорилт** Эзлэжэр ярих, ярилцаж санаагаа дэлгэрүүлэх.

- Хүүхдүүдтэйгээ тойрон суугаад үлгэрийн 6-р хуудсан дахь Вильф усны дэргэд юу хийсний ярилц.
- Хүүхдүүдээр усны аюулын талаар сануулж, усны дэргэд тоглох нэг санааг өргөжүүл.

### Амьдрал, хичээлийн уялдаа

◀ ▶ Эруул тайван амьдралын хэв маягийг сонгох.

### Бичих үйл ажиллагаа

**Зорилт** Үлгэрийн бүтцийг ашиглаж өөрт тохиолдсон явдлаа адил хэлбэрээр бичүүл.

- Хүүхдүүдээр үлгэрт юу гарсныг хэлүүлээд, хялбаршуулсан хувилбарыг самбар дээр бич.
- Өөр хүүхдүүд болон зугаалгын тухай бичих юм бол хялбаршуулсан үлгэртэй ижил хэсгүүдийнх нь талаар ярилц.
- Хүүхдүүд танил болсон хэсгүүдийг хэрэглэснээр, бичих үйл ажиллагааг бий болгоход туслах суурь нь болдог юм.
- Хүүхдүүдээр өөрсдийнх нь зугаалгын талаар бичүүлж, эх загварыг хэрэглүүл.



## Динозавруудын өлгий

### Уншихын өмнө

- Хавтсан дээрх зургийг хар. Номын гарчгийг болон арын хавтсан дээрх үгнүүдийг уншуул.
- Үлгэрт юу тохиолдохыг нь хэлүүл.

### Унших үед

- Хүүхдүүдээр үлгэрийг уншуул. Уншиж байхад нь тэднийг магтан урамшуулж, шаардлагатай бол сануулан хэлж ег. Сэтгэл хөдлөлөө илэрхийлж уншихад нь урамшуул.
- Өмнөх үлгэртэй холбогдсон холбоо болон энэ үлгэрийг ойлгоход туслах асуултууд тавьж, хүүхад нэг бүрийн хариултыг сонс. Жишээ нь: Вильф яагаад гялгар уут нэг хөлдөө өмссөн бэ? Үлэг түрвэл яагаад үргэсэн гэж бодож байна вэ? Биф яагаад зургийн аппаратаараа үзэг түрвэлийн нэг ч зургийг аваагүй вэ?

#### Ажиглалт

- Олон давтагдах үгсийг чөлөөтэй өөртөө итгэлтэйгээр унших
- Чанга уншиж байхдаа хэлзүй болон шинж тэмдгийг тооцоолох зэргийг шалга.

## Бүлгээр болон бие дааж унших үйл ажиллагаа

### Эхийн төвшинд ажиллах

**Зорилт** Үйл явдлын бүтэц дараалалд хэлний цаг хугацааг зөв хэрэглэх.  
Танд дараах үгийн картууд хэрэг болно. «эхлээд, яаралтай, энэ хооронд, түүний дараа, гэнэт, тэгээд, дараа нь» Мөн эдгээр өгүүлбэрүүдийг бичнэ.

Үлэг гүрвэл доошоо урсав.  
Надим өндөг олсон.  
Чип мөр олов.  
Вильф уулан дээр гүйж гарав.  
Биф зураг авав.  
Өндөгнөөс бяцхан үлэг гүрвэл гарсан.  
Биф нэг дохиурыг авсан.

- Хүүхдүүдээр өгүүлбэрийг зөв дараалалд тавиул. Үгийн картуудаа тохирох газар нь байрлуул.

**Ажиглалт**

Хүүхдүүд өгүүлбэрийг зөв дараалуулж үлгэрийг ярьж чадаж байна уу?

### Өгүүлбэрийн төвшинд ажиллах

**Зорилт** Цэг тэмдгийг зөв хэрэглэж бичсэнээр дахин үнших.

- Номын зургийг хүүхдүүдэд гүйлгэн харуулаад тэдний хамгийн дуртай нэгийг нь сонгуул.
- Зурагт зориулж хоёр шинэ өгүүлбэр бичүүл.
- Өгүүлбэрийг чанга үншуулаад, ойлгосныг нь шалга.

**Ажиглалт**

Хүүхдүүд өгүүлбэрийг том үсгээр эхэлж бичиж, өгүүлбэрийн төгсгөлд цэг тавьж байна уу?

### Үгийн төвшинд ажиллах

**Зорилт** Эгшиг үсгийн хэрэглээ болон ойлголтыг батжуулах.

- Номыг хүүхдүүдээр гүйлгэн харуулаад нэг, хоёр, гурав, дөрвөн эгшиг үсэг бүхий үргүүдийг олуул.
- Тэд дөрвөөс дээш эгшигтэй үг олж байна уу?
- Эгшиг үсгийн ач холбогдолгыг тайлбарлаж, хүүхдүүдийн олсон нэг хоёр үгийг самбар дээр жагсаан бичээд түүн доторх эгшигнүүдийг баллаж, тэрхүү үгүүдээ үншуулахыг оролд.

**Ажиглалт**

Хүүхдүүд урт үгийг сонгохдоо эхийг гүйлгэн уншиж байна уу?  
Эгшиг авиа бол үгэнд чухал хэрэгтэй гэдгийг ухаарч байна уу?

**Ярих, сонсох үйл ажиллагаа**

**Зорилт** Холбогдох тодорхойлолтуудыг оруулах, хувийн үүрэг хариуцлагыг бий болгож дэмжих.

- Үлэг гурвэлийн өндгийг дарж байхад Биф юу хийж байгаа талаар ярилц. Хүүхдүүдийг зэлжээр Бифийн дүрд тоглуул.
- Хүүхдүүдээр Бифийн юу хийсэн талаарх асуултыг бодож олуул.

**Бичих үйл ажиллагаа**

**Зорилт** Хэлний цаг хугацааг үйл явдлын бүтэц, дараалалд хэрэглэх.  
Танд цаг хугацаатай холбогдох үгийн картууд хэрэг болно.

- Хүүхдүүдээр үлгэрийг ярилцуулж, 5-н түлхүүр үйл явдлыг сонгож аваад өгүүлбэр бичүүл. Тэднийг номоо хэрэглэхийг нь зөвшөөр. Өгүүлбэрийн эхний үгийг авч картан дээр бич.
- Тэгээд энэхүү өгүүлбэрүүд нь түлхүүр үйл явдлын дарааллыг хэлж өгөх болно.



## Эрдэнэсийн авдар

### Үншихын өмнө

- Хавтсан дээрх зургийг үзүүлж үлгэр юуны тухай өгүүлж байгааг асуу.
- Гарчгийг болон арын хуудасны үгийг уншуул.
- Үлгэрт юу тохиолдно гэж бодож байна вэ?
- Хүүхдүүд наймаалжтай тааралдана гэж бодож байна уу?

### Үнших үед

#### Ажиглалт

Хүүхдүүдээр үлгэрийг уншуул. Үншиж байхад нь магтаж урамшуулж, шаардлагатай бол сануулан хэлж ег.

- 17-р хуудсан дээрх зургаас юу болж байгааг хүүхдүүдээс асуу.
- Хүүхдүүдээр «өөр» гэдэг үгийг уншуулаад энэхүү адал явдал хэрхэн өөр болж байгааг хэл.
- 19-р хуудсан дээрх «бодоход» гэдэг үгийн оронд «хэлэхэд» гэдэг үгийг яагаад хэрэглэснийг асуу.
- Олон давтагдах үгсийг чөлөөтэй үнших.
- Хэлзүйн болон тохиромжтой цэг тэмдгийг хэрэглэж үнших.
- Үгийн утгыг тайлах янз бүрийн аргыг хэрэглэх.

## Бүлгээр болон бие даан үнших үйл ажиллагаа

### Эхийн төвшинд ажиллах

**Зорилт** Улгэрийн өрнөл хэсэгтэй холбоотой үйл явдлын шалтгааныг мэдэж ярилцах.

- Улгэрт тохиолдож байгаа гурван зүйлийг хүүхдүүдээр бодож олуулаад самбар дээр жагсаан бич. Жишээ нь:

Хүүхдүүд усанд сэлэх шалгалт өгдөг. Биф, Чил хоёр загас нөөшлөх сав авахаар дэлгүүр лүү явдаг. Хүүхдүүд усан доор адал явдалтай учирдаг.

- Хүүхэд бүрээр нэг үйл явдлыг сонгуулж, үйл явдлын шалтгааныг «учраас» гэдэг үгийг ашиглан өөрийн үгээр бич.

**Ажиглалт**

Үйл явдлын учир шалтгааныг тайлбарладаг «учраас» гэдэг үгийн хэрэглээг хүүхдүүд ойлгож байна уу?

**Өгүүлбэрийн төвшинд ажиллах**

**Зорилт**

Янз бүрийн тэмдэг хэрэглэх. Жишээ нь: сум нь үйл явдлын дараалал холбоог үзүүлдэг.

Та самбар дээр эдгээр өгүүлбэрүүдийн хуулбарыг таамгаар дараалуулан бич.

Ид шид ажиллаж эхэлсэн.  
Авдар дээр наймаалж байхыг тэд харав.  
Тэд завь уруу сэлзв.  
Хүүхдүүд усан доор шумбаж чадсан.  
Тэд усан доор хөлөг онгоц байхыг харсан.  
Наймаалж цааш сэлзв.  
Энэ алтаар дүүрэн байв.  
Хүүхдүүд авдрыг онгойлгосон.

- Хүүхдүүдэд цаас тарааж өг. Эдгээр өгүүлбэрүүдийг уншуулаад, аль нь үлгэрт давтагдаж байгааг харуулахын тулд үйл явдлыг сумаар заа.
- Эхнээс нь дуустал давтагдаж байгаа үгнүүдийг хүүхдүүд бичиж чадаж байна уу?

**Ажиглалт**

Зөв дарааллыг мэдэхийн тулд үлгэрийг дахин унших хэрэг байна уу?

Эхийг харалгүйгээр цаад өгүүлбэрүүдийг тогтоож чадаж байна уу?

## Үгийн төвшинд ажиллах

**Зорилт** Дүрэмгүй нийтлэг үргүүдийг үсэглэх.

- 18, 19-р хуудасны зургийг хүүхдүүдэд харуул.
- Тэдний харж байгаа янз бүрийн үгийг нэрлүүлж бичүүл.

**Ажиглалт**

Хүүхдүүд нийтлэг өнгийн нэрийг мэдэж байна уу?  
Хүүхдүүд бие даан үсэглэхийг оролдож байна уу?

## Ярих, сонсох үйл ажиллагаа

**Зорилт** Гол утга санаан дээр төвлөрөх болон тодорхойлох.

- Хүүхдүүдтэйгээ тойрон суугаад энэ адал явдалд хэн байхгүй байгааг тэд тааж чадаж байна уу?
- Киппер юу мэдрэх байгаа шалтгааныг сануулж зэлжээр асуу.
- Усны аюулгүй байдлын талаар ярилц.

## Амьдрал, хичээлийн уялдаа

◀ ▶ Сэлж сурх болон усны аюулгүй байдал.

## Бичих үйл ажиллагаа.

**Зорилт** Энгийн заавар бичих.

- Үлгэрийн 4-6-р хуудсан дээр дуруүдийн өгч буй усанд сэлэх шалгалтыг ярилц.
- Хүүхдүүдээр дуруүд шалгалт өгөхдөө юу хийх хэрэгтэй байсан талаарх зааврыг бичүүл.
- Самбар дээр дугаарласан зөвлөгөөнүүдийг бич. Жишээ нь: сэлэх шалгалт  
1. Усан сан уруу үсэр.  
2. 10 метр сэлэх.
- Хүүхдүүд жагсаалтын төгсгөлд өөр заавруудыг бодож олж чадаж байна уу?







## Оксфордын уншлагын мод

Шатлал 6  
Түүхүүд

Оксфордын уншлагын мод цуврал 6 нь шидэт түлхүүрийн аргаар олон янзын уран зөгнөлийн орчинд өрнөдөг. Хэдийгээр олон давтагдах угсийн хэрэглээ өргөн байсан хэдий ч адал явдлууд нь илүү их өргөн хүрээний угсийн санг багтааж байгаа юм.

Гарчиг бүрийг уншихад багшийн тэмдэглэл:

- Уншихын ёмиж болон унших үед зориулсан санамж зөвлөгөө өгдөг.
- Бүлгээр болон бие даах уншихад эх, өгүүлбэр, үгийн төвшинд ажиллах үйл ажиллагаагаар хангадаг.
- Ярих сонсох үйл ажиллагаанд зориулсан санаа гаргаж өгдөг.
- Амьдрал хичээлийг уялдуулдаг.

Эдгээр нь:

- Харилцан хамаарал бүхий угсийн сангийн хүснэгт
- Бусад Оксфордын уншлагын цувралын нөөц материалууд зэргийг багтаадаг юм.

Гэртээ авч явах карт нь мөн хэрэгтэй юм. Энэ номыг хүүхдүүдтэйгээ гэртээ ушидаг эцэг эхчүүдэд нөхөрсөг санамж зөвлөгөө өгч, тоглох тоглоомор хангадаг юм.

Шатлал 6. Үлгэрүүд

1. Цэцэрлэгт хүрээлэнд
2. Киппер ба аварга биетэн
3. Зугаалга
4. Динозавруудын орон
5. Эрдэнэсийн авдар

**БАГШИЙН НОМ**



Хэвлэн нийтлэлийг  
Интерпресс ХХК



Дэлхийн банктай хамтран хэрэгжүүлж буй «Хөдөөгийн боловсролыг дэмжих (READ) төсөл»-ийн хүрээнд хэвлэв. Худалдахыг хориглоно.